

Огноо 2021/02/26

№ 04/21

Улаанбаатар

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлах тухай**

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 64 дүгээр зүйлийн 64.2 хэсэг, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3, 71.4 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3-р заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12-р сарын 14-ний өдрийн 377 тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02-р сарын 26-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Фронтиер Лэнд Групп” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 4-р сарын 7-ны лхагва гарагт 15:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бага тойруу, Пума Империал зочид буудлын хурлын бага танхимд хуралдах цахим/биеэр оролцох хэлбэрээр хуралдуулсугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.  
Үүнд:
  - 2.1 Компанийн үйл ажиллагааны тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлт батлах
  - 2.2 Компанийн 2020 оны аудитаар баталгаажсан санхүүгийн тайланд хийсэн компанийн ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дүгнэлт батлах
  - 2.3 Компанийн хэлбэр өөрчлөх буюу ХХК болгох асуудлыг хэлэлцэх
  - 2.4 Компани хувьцаагаа эргүүлэн худалдаж авах тухай
  - 2.5 Шаардах эрх хэрэгжүүлэх тухай /эргүүлэн худалдаж авах хувьцааны үнийг хэлэлцэх/
  - 2.6 Халаасны хувьцааг бичилтээс хасах тухай
  - 2.7 Хөрөнгө худалдан борлуулах тухай
  - 2.8 Их хэмжээний хэлцэлийг хэлэлцэх тухай /Морьт Импекс ХХК-тай хийсэн гэрээний сунгалт болон хөрөнгө оруулалтын гэрээний сунгалт/
  - 2.9 ТУЗ-ийн гишүүн чөлөөлөх, шинээр сонгох
  - 2.10 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсөв
  - 2.11 Ногдол ашиг хувиарлахгүй тухай шийдвэрлэсэн ТУЗ-ийн тогтоол танилцуулах
  - 2.12 Бусад

3. Олон нийтэд мэдэгдэх өдрийг 2021 оны 3 дугаар сарын 03-ны өдрөөр тогтоон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлаж, 2021 оны 3 дугаар сарын 18-ны өдөр давтан зарласугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2021 оны 3-р сарын 18-ний өдрөөр тогтоосугай.
5. “Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг холбогдох баримт бичгүүдийн хамт 2021 оны 3-р сарын 1-ний өдөр Санхүүгийн Зохицуулах Хороо болон “Монголын хөрөнгийн бирж” ХК-д хүргүүлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай зарыг хавсралт 1-р баталж, 2021 оны 3-р сарын 3 болон 2021 оны 3-р сарын 18-ны өдрүүдэд тус тус Санхүүгийн Зохицуулах хороноос гаргасан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасны дагуу олон нийтэд зарласугай.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийн жагсаалтыг хавсралт 2-р баталж, энэхүү баримт бичгийг 2021 оны 3-р сарын 08-ны өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлын энгийн санал авах саналын хуудсыг хавсралт 3-р, акумулятив аргаар санал авах саналын хуудсыг хавсралт 4-р баталж, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг 2021 оны 4-р сарын 7-ны өдрийн 15:00 цаг хүртэл хүлээн авахыг тооллогын комисс /М. Батбаатар/-т үүрэг болгосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Г. Оюунболдыг томилсугай.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:  
Тооллогын комиссын дарга: Г. Алтан-Оч  
Гишүүд: М. Батбаатар
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:  
Комиссын дарга: О. Амартүвшин  
Гишүүн: Г. Алтаймаа  
Гишүүн: У. Анар

12. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдон гарах зар мэдээ болон бусад зардлыг компанийн үйл ажиллагааны холбогдох зардлаас гаргахыг Гүйцэтгэх захирал /О.Амартувшин/-д зөвшөөрсүгэй.
13. Онцгой нөхцөл байдалтай холбогдуулан Гамшгаас хамгаалах хууль тогтоомж, Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон эрх бүхий байгууллагаас гаргасан тогтоол шийдвэртэй уялдуулан Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулахыг хурлын дарга О. Амартувшин, хурал зохион байгуулах комисс У. Анаар, Г. Алтаймаа нарт үүрэг болгосугай.
14. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо Г. Батбилэгд үүрэг болгосугай.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга

Д. Үнэнбат

